

Батлав. МБСҮТөвийн дарга  
Ц.Батдорж



Батлав. БПК-ийн захирал  
Г.Нямдулам



БАРИЛГЫН ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН НЭРЭМЖИТ  
“ӨРӨГ УГСРАГЧ” МЭРГЭЖЛИЙН БАГШ НАРЫН АНХДУГААР УРАЛДААНЫ  
УДИРДАМЖ, ДААЛГАВАР

Зохион байгуулагч: Барилгын политехник коллеж, барилгын мэргэжлийн зөвлөл

Улаанбаатар хот

2018 он

## Агуулга

**Нэг.** Уралдааны зорилго

**Хоёр.** Хамрах хүрээ

**Гурав.** Уралдаан болох газар, хугацаа

**Дөрөв.** Уралдааны зохион байгуулалт

**Тав.** Уралдааны шаардлага, бэлтгэл ажил

**Зургаа.** Уралдаанд оролцогчийн ажилбарт үнэлгээ өгөх, байр эзлүүлж дүгнэх

**Долоо.** Ажлын зураг

**Найм.** Шагнал, урамшуулал

### Нэг. Уралдааны зорилго

Барилгын сайдаар олон жил үр бүтээлтэй ажилласан О.Тлейханы алдрыг мөнхжүүлэх зорилгоор Барилгын политехник коллеж нь өрөг угсрагч мэргэжлийн багш нарын анхдугаар уралдааныг жил бүр уламжлал болгон зохион байгуулах бөгөөд мэргэжлийн багш нарын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, туршлага солилцох, барилгын мэргэжлийн чадамжийн төвийн үйл ажиллагааг сурталчлахад оршино.

### Хоёр. Хамрах хүрээ

Политехник коллеж, МСҮТ болон бусад мэргэжлийн сургуулиудын “Өрөг угсрагч” мэргэжлийн багш нар хамрагдана.

### Гурав. Уралдаан болох газар, хугацаа

Уралдаан болох газар	Улаанбаатар хот, БГД, Энхтайваны өргөн чөлөө-35, баруун 4 зам Барилгын политехник коллеж
Уралдаан болох өдөр	2018 оны 11-р сарын 19,20-ны өдөр
Уралдаан эхлэх болон дуусах цаг	10:00-17:00 /Цайны завсарлага 1 цаг /

### Дөрөв. Уралдааны зохион байгуулалт

1. Техникийн зөвлөгөөн 2018 оны 11 дугаар сарын 18-ны 09:00 цагт БПК-ын 205 тоотод болно.
2. Нэг сургуулиас 1 багш туслахгүй оролцоно.
3. Бүртгэлийг Барилгын политехник коллежийн сургалтын алба №201 тоотод хүлээн авах бөгөөд [Bayartsetseg@cc.edu.mn](mailto:Bayartsetseg@cc.edu.mn) цахим хаягаар 2018 оны 11 сарын 15-ны 18:00 цаг хүртэл бүртгэнэ.
4. Бүртгүүлэхдээ оролцогч нь нийгмийн даатгалын дэвтэр, иргэний үнэмлэх, 3x4 хэмжээтэй цээж зураг, оролцооны төлбөр болох 200.000 төгрөгийг ....тоот дансанд шилжүүлсэн баримтын хуулбарыг авчирна.
5. Уралдаанд оролцогч нь уралдааны техникийн баримт бичгийг /удирдамж/ мөрдөж ажиллахын зэрэгцээ шүүгч нарын шаардлагыг биелүүлж ажиллана.
6. Шүүгчид зөрчил гаргасан, шаардлага биелүүлээгүй оролцогчдыг ерөнхий шүүгчид мэдэгдэж тухайн зөрчлийг арилгуулах эрхтэй бөгөөд ерөнхий шүүгч нь зөрчил гаргасан хүмүүст холбогдох арга хэмжээ авч ажиллана.
7. Уралдаан болж буй хэсэгт гар утсаа унтраах, чимээ шуугиангүй, хэрүүл маргаангүй нам гүм байвал зохино. Ямар нэг асуудал гарсан тохиолдолд оролцогч нь шүүгч нарт биеэр мэдэгдэнэ.
8. Шүүгч нарын зөвшөөрлөөр уралдааныг түр хугацаагаар зогсоож болох бөгөөд уралдааны хугацаа тооцогдсон хэвээр байх болно.
9. Бусад гадны хүмүүс тэмцээнийг тодорхой зайнаас ажиглаж сонирхохыг зөвшөөрнө.
10. Уралдааны шүүгчдийн бүрэлдэхүүн 100% ирцтэй байна.
11. Уралдаан тусгай дохиогоор эхлэнэ.

### Тав. Уралдааны шаардлага, бэлтгэл ажил

1. Зохион байгуулагдах газар, өрөг өрөх талбайг урьдчилан бэлтгэсэн байна.
2. Зуурмаг зуурах машиныг талбайд байрлуулан зуурмагийг бэлтгэсэн байна.

3. Талбайн зохион байгуулалтыг зургийн дагуу тоосгыг өнгө бүрээр нь төрөлжүүлэн хурааж бусад материал, багаж хэрэгслийг байрлуулсан байна.
4. Уралдаанд оролцох оролцогч нь ажлын даалгавар зурагт заасны дагуу тоосго, блокыг /зураг / зүсэж бэлтгэнэ.
5. Уралдаанд оролцогч нь хувийн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцас, ашиглагдах багаж хэрэгсэл болон бусад бэлтгэлээ хангасан байна.
6. Ажлын даалгаварт MNS138:2010, MNS3835:2003, MNS195:1991 стандартын шаардлага хангасан тоосго болон бусад материал, орчин үеийн чанарын шаардалага хангахуйц багаж хэрэгсэл сонгож хэрэглэнэ.
7. Уралдааны төгсгөлд эцсийн бүтээгдэхүүн нь өрөгт бүтээц байна. Уг бүтээц нь нийт / зураг 1-с / бүрдсэн байна.
8. Зургийн дагуу ажлын даалгаврыг гүйцэтгэлийн шалгуураар шалгана.
9. Оролцогч 10 мин ба түүнээс дээш хугацаагаар хоцорсон тохиолдолд уралдаанаас хасагдсанд тооцно.

### **Зургаа. Уралдаанд оролцогчийн ажилбарт үнэлгээ өгөх, байр эзлүүлж дүгнэх**

Үнэлгээний шалгуур үзүүлэлтийг техникийн зөвлөлгөөн болох өдөр танилцуулна. Уралдааны даалгаврын гүйцэтгэлийг үнэлэхдээ шүүгч бүр үнэлгээний шалгуур үзүүлэлтэд заасны дагуу үнэлэж дундаж оноог гаргана. Дундаж онооны байдлаар цуваагаар байр эзлүүлнэ


**Долоо.** Ажлын зураг- /хавсралт№1/

**Найм.** Шагнал, урамшуулал


- 1-р байр-1 Өргөмжлөл, мөнгөн шагнал
- 2-р байр-1 Өргөмжлөл, мөнгөн шагнал
- 3-р байр -1 Өргөмжлөл, мөнгөн шагнал
- Тусгай байр -1 . Өргөмжлөл, мөнгөн шагнал
- Бүх оролцогчдод батламж олгоно.

О.Тлейханы нэрэмжит "Алтан гадас" одонт Барилгын Политехник Коллежийн зохион байгуулах "Өрөг Угсрагч" Мэргэжлийн багш нарын ур чадварын улсын анхдугаар уралдаан



## ОГЛЛОЛ 1-1




Тоосгоны хэмжээ



Заадасны хэмжээ



## ОГЛЛОЛ 2-2



Тайлбар: Өргийн босоо болон хэвтээ заадсын хэмжээг 10мм-ийн зузаантай дөрвөлжин ба дугуй ухлаадастай заадсаар гүйцэтгэнэ.

Ур чадвар: Өрөг угсрагч  
Масштаб: М1:100, М1:50

Зурсан: Э.Оюунболд (Монгол улсын мэргэшсэн инженер)  
Ажлын даалгавар Бүх хуудас 1/2

МСУТ, Политехник Коллежуудын багш нарын дунд зохиогдох "Өрөг угсрагч" мэргэжлийн ур чадварын улсын Анхдугаар уралдаан-2018

